СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

2025 оны 07 сарын 31-ний өдөр Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 06 дугаар тогтоолоор батлсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд орсон дараах ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтын нэр: Хөнгөн аж үйлдвэрийн салбарт “Нэхмэл эдлэл, гутал, хувцас, арьс шир үйлдвэрлэлийн салбарт баримтлах практик дүрэм” стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сайн туршлагыг сурталчлах богино хэмжээний нэвтрүүлэг (story telling) бэлтгэж олон нийтэд сурталчлах

Ажлын даалгавар татаж авах холбоос: https://publuu.com/flip-book/938033/2058163

Төсөвт өртөг: 15 000 000 төгрөг

Сонгон шалгаруулалтад ирүүлэх саналаа 2025 оны 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана.

Сонирхсон оролцогч нь Захиалагчид Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг битүүмжлэн цаасаар 2% (хоёр хувь) болон pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр ирүүлнэ үү.

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Хөдөлмөрийн ордон, 4-н давхар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 407 тоот

Холбоо барих утас, цахим шуудангийн хаяг: 7715-4949, 7712-4949, Bnarantsetseg@osh.gov.mn

Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.

Цахим шуудангаар илгээсэн баримт бичиг, тодруулга хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.